



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 17

Мандалговь


**Хөрөнгө данснаас хасах тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.9 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 700,000 /долоон зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын дарга Ю.Дашдаваад даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ